




**Эрчим хүчний яамны Ёс зүйн дэд хорооны
2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө**

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах эзэн
1	1.Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, нөлөөллийн аяныг хэрэгжүүлж ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	1.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан ёс зүйн чиглүүлэх сургалтын хөтөлбөр, сэдвийг боловсруулах, зохион байгуулах	Ёс зүйн чиглүүлэх сургалтад төрийн албанд шинээр орсон албан хаагчдын хамрагдалт, хувь	100	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг
2		1.2.Байгууллагын хэмжээнд ёс зүйн нөлөөллийн сарын аяныг зохион байгуулах	Зохион байгуулах нөлөөллийн аян, тоо	2	III, X сар	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг
3		1.3.Жил бүрийн 11 дүгээр сард зохион байгуулагддаг Ёс зүйн нөлөөллийн сарын аяныг сурталчилах, таниулах, түгээх ажлыг зохион байгуулах	Ёс зүйн нөлөөллийн сарын аяныг сурталчилан таниулах ажлын зохион байгуулалт, хувь	100	XI сар	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг
4		1.4.Албан хаагчдын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд, эрсдэл бүхий хэсэгт чиглэсэн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах	Зохион байгуулах сургалт, тоо	2-3	V-XI сар	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг
5		1.5.Яамны удирдах албан тушаалтнуудад чиглэсэн ёс зүйн манлайллын чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтад удирдах албан хаагчдын хамрагдалт, хувь	90-ээс дээш	II, III улирал	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг

6		1.6.Төрийн албаны ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагыг агуулсан ёс зүйн тайлбар, гарын авлага, зөвлөмж, заавар боловсруулж, албан хаагчдад түгээх, сурталчилах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх	Гарын авлага, заавар, зөвлөмжөөр хангах ажлын хэрэгжилт, хувь	100	III сар	Ёс зүйн дэд хорооны гишүүд
7	2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	2.1.Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийх ажлыг зохион байгуулах	Эрсдэлийн үнэлгээний тайлан, тоо	1	IV сар	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг
8		2.2.Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагчдаар ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Эхний хагас жил	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг
9	Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлнэ.	Холбогдох хуулиар харъяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах	Холбогдох хууль, журмын дагуу хүлээн авах, бүртгэх ажлын хэрэгжилт, хувь	100	Тухай бүр	Нарийн бичиг
10		Иргэн, албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээллийг гишүүдэд хуваарилах, хянан шалгах	Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, хуралдааны дэгийн хэрэгжилт, хувь	100	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг, гишүүд
11		Ёс зүйн дэд хорооны хуралдааныг зохион байгуулах, хэлэлцэх, гомдол мэдээллийн дагуу холбогдох дүгнэлтийг гаргах				
12		Ёс зүйн хариуцлагын бүртгэлийн хуудсыг хэрэглэж хэвших, ил тод байдлыг хангах	Ёс зүйн хариуцлагын цахим бүртгэл хөтөлсөн байдал, хувь	100	Жилдээ	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг
13	3.Ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажлын ил тод, нээлттэй байдлыг хангана.	3.1.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг Ёс зүйн хороонд тайлагнаж, яамны цахим хуудсанд байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах	Тайлангийн давтамж	2 удаа	Хагас, бүтэн жил	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг

14		3.2.Олон нийтэд ил тод болгохоор заасан ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг тухай бүр нээлттэй байршуулах	Олон нийтэд нээлттэй байршуулах мэдээлэл, хувь	100	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг
15		3.3.Байгууллагын мэдээллийн самбарт Төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээрх буланг ажиллуулж, тогтмол шинэчлэх, мэдээллээр хангаж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг
16		3.4.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны хүрээнд холбогдох дээд байгууллагаас ирүүлсэн дүгнэлт зөвлөмж, албан даалгавар, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тайлагнах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг

---oOo---